

2025 он 10 сар 20 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

“Говь” ХК нь “Таван Богд Холдингс” ХХК болон түүний охин компаниудтай хамтран “ХААН” банктай байгуулсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК түүний охин компаниудын хамт “ХААН” банктай байгуулсан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ЗЭНГ24/39 тоот Зээлийн эрх нээх гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн эрхийн хэмжээг 13,000,000,000 /арван гурван тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлэн 110,000,000,000 /нэг зуун арван тэрбум/ төгрөг болгон Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй,
 - 1.2. “Таван Богд Холдингс” ХХК нь 100.0%-ийн хувьцаа эзэмшдэг охин компани “Таван Богд Моторс” ХХК-ийг ЗЭНГ24/39 тоот Зээлийн эрх нээх гэрээний хамтран зээлдэгчээс хасахыг шийдвэрлэсүгэй.
 - 1.3. “Таван Богд Холдингс” ХХК нь 74.4%-ийн хувьцаа эзэмшдэг охин компани “Таван Богд Капитал ҮЦК” ХХК-ийг ЗЭНГ24/39 тоот Зээлийн эрх нээх гэрээнд хамтран зээлдэгчээр нэмэх, түүнтэй холбоотой дараах нэмэлт нөхцөлүүдийг зээлийн эрх нээх гэрээнд тусгахыг зөвшөөрсүгэй.
 - 1.3.1. Монгол банк болон СЗХ-ны шаардлагын дагуу Банк бус санхүүгийн байгууллага, лизинг, барьцаалан зээлдүүлэхтэй холбоотой аливаа бизнесүүдийн бондод хөрөнгө оруулахыг хориглох;
 - 1.3.2. “Таван Богд Капитал ҮЦК” ХХК-ийг ЗЭНГ24/39 тоот Зээлийн эрх нээх гэрээнээс ашиглах лимитийг 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөгөөс хэтрүүлэхгүй байх;
 - 1.3.3. “Таван Богд Капитал ҮЦК” ХХК нь андеррайтерийн үйчилгээний үйл ажиллагааны хүрээнд аливаа компанийн гаргасан нэг болон нийт үнэт цаасыг түүний 50 /тавин/ хувиас хэтрэхгүй хэмжээгээр худалдан авах;
2. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
3. Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, барьцааны нэмэлт гэрээ, холбогдох бусад гэрээ, бичиг баримтад Говь ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал /Б.Оргил/-д олгосугай.



20²⁵ он 10 сар 20 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



(Handwritten signatures)

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР